

Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2017 он

2017 оны 5-р сарын нэгнээс 2018 оны 5-р сарын нэгэн хүртэл

Глоб Интернэшнл төв

Гарчиг

Өмнөтгөл

Нэг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчил 2005-2017 онд

Хоёр. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг иргэний болон эрүүгийн хэрэг

Гурав. Хэвлэл мэдээллийн эрх зүйн хүрээ

- 3.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа
- 3.2. Хэвлэлийн эрх чөлөө ба сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа
- 3.3. Мэдээллийн эрх чөлөө ба хязгаарлалт
- 3.4. Сонгууль ба хэвлэл мэдээлэл
- 3.5. Нэр төр гутаахтай холбоотой зохицуулалт
- 3.6. Агуулгын хязгаарлалт
- 3.7. Бусад зохицуулалт



Бэлтгэсэн:

Х.Наранжаргал

Ц.Мөнхжин

Л.Галбаатар

Г.Билгүүн

Өмнөтгөл

Жил бүрийн 5-р сарын 3-ны өдөр дэлхий даяар тэмдэглэдэг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр” (ДХЭЧ)-т зориулан Монгол дахь Хэвлэлийн эрх чөлөөний тухай ээлжит тайлангаа та бүхэнд толилуулж байна. ЮНЕСКО-гоос 2018 оны ДХЭЧ-ний өдрийг “Эрх мэдлийг хяналтдаа байлгах нь: Хэвлэл мэдээлэл, шударга ёс, хууль дээдэх ёс” сэдвийн дор тэмдэглэнэ. Чөлөөт, хараат бус, ёс зүйт хэвлэл мэдээлэл бол эрүүл саруул, шударга ёст нийгмийн хэмжүүр юм.

Өнгөрсөн 2017 он хэвлэлийн эрх чөлөөний тухай эргэн эргэцүүлэх, тунгаан бодох олон даалгаврыг бидний өмнө тавилаа. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны аян үүний нэг байсан юм. Монголын сонгогчид, улс төрийн сонгуулийн бохир технологид хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээг хэрхэн урвуулан, хэтрүүлэн ашигласны гэрч болсон юм. Ийм үед шударга өрсөлдөөн, шударга сонгуулийн зарчим гагцхүү мөрөөдөл болон үлдсэн нь харамсалтай. Ийм учраас ЮНЕСКО-гоос нийтээрээ хэлэлцэн мэтгэлцвэл зохих гурван дэд сэдвийн эхнийхийг “Хэвлэл мэдээлэл, мэдээлэл олж авах эрх ба сонгууль”, “Хэвлэлийн чөлөө, сэтгүүлчийн аюулгүй байдлыг дэмжих эрх зүйн тогтолцоо”, “Цахим орчин дахь эрх чөлөө, өөрийн зохицуулалт” хэмээн тодорхойлсонд олзуурхаж байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеэр тархсан популист суртал нэвтрүүлэг, үзэн ядалтыг дэвэргэсэн, хүчирхийлэлд турхирсан мэдээллийн бурууг нийтээрээ нийгмийн сүлжээ хэрэглэгчдэд тохож, хэвлэл мэдээлэл улс төрийн ухуулга сурталчилгааны бай болов. Энэ бүхэн нь ёс зүйт, хариуцлагатай сэтгүүл зүйн суурь, гол зарчмуудад эрсдэл учруулж байгаа нь Монголд хэвлэлийн эрх чөлөөнд аюул тулгарч буйн шинж юм. Ямар ч аргаар хамаагүй ялалт байгуулах гэсэн улс төрийн явцуу сонирхол Монголд газар авч, ардчиллын үнэт зүйлийг үл тоомсорлох нь хэвийн үзэгдэл болжээ. Энэ нь иргэдийн үнэн бодит мэдээлэлтэй байх эрх ноцтой зөрчигдөхөд хүргэж байна.

2017 оны 5-р сарын 18-нд УИХ-аас Зөрчлийн тухай хуулийн, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлав. Хоёр хууль 2017 оны 7-р сарын нэгнээс хэрэгжиж эхэлсэн юм. Энэ нь хэвлэлийн эрх чөлөөнд асуудал дагууллаа. Энэ хуулийн “Гүтгэх” хэмээх 6.21-р зүйлээр хэвлэл мэдээлэлтэй холбоотой 49 хэрэгт 98 сая төгрөгийн торгууль тавьсан нь эдийн засгийн цензур болон хувирав.

2018 оны 1-р сард хэвлэлийн эрх чөлөөний эсрэг балмад тохиолдол гарчээ. Цагдаагийн ажилтан хувийн компанийн хуулийн зөвлөх, компьютерийн шинжээчийн хамт мэдээний сайтын байранд зөвшөөрөлгүйгээр дайран орж, айлган сүрдүүлэн өөрийн захиралтай холбоотой мэдээллүүдийг устгахыг сэтгүүлчдэд тулган шаардсан байна. Мөн 2018 оны 4-р сард 9 сэтгүүлчийн утсыг чагнасан тухай мэдээлэл олон нийтэд ил болж, албан

тушаалтнуудад эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж буй тухай Нийслэлийн Прокурорын газраас зохион байгуулсан хэвлэлийн бага хурлынхаа үеэр мэдэгдлээ.

Улс төрчид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг хатуу хязгаарлах, нийгмийн сүлжээг хаах тухай үе үе мэдэгдэл хийх боллоо. Улс төрийн башир аргын золиос нь иргэд, тэдний төлөө ажлаж буй жирийн сэтгүүлчид байх вий хэмээн эмээж байна.

НҮБ-ын Хүний эрхийн хороо 2017 оны 7-р сарын 6-7-ны өдрүүдэд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн тухай Монголын Засгийн газрын 6 дахь ээлжит тайланг хэлэлцэн, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг аливаа хэлбэрээр хязгаарлахдаа ИБУТЭОУП-ын гурав дахь зүйлд нийцүүлэх, сэтгүүлчдийг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдлийг шуурхай мөрдөн шалгаж, буруутанд зохих харицлага хүлээлгэх зөвлөмж өгсөн билээ.

Манай байгууллагаас үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчилд хийсэн мониторингийн дүнгээр тайлангийн хугацаанд буюу 2017 оны 5-р сараас хойших нэг жилд нийт 140 сэтгүүлч, ХМХ-д холбогдох үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчлийн 182 тохиолдол бүртгэгджээ. Зөрчил үйлдэгчийн 30 гаруй хувь нь улстөрч, төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага ажээ. Мөн редакцийн цензур өмнөх жилээс нэмэгдсэн болохыг нээлттэй асуулгын дүнгээс харж болохоор байна. 2017 оны 5-р сараас 2018 оны 5-р сарын хооронд Монголын шүүхүүд хэвлэл мэдээллийн эсрэг нэр төр гутаахтай холбоотой иргэний 12, эрүүгийн 0 хэргийг шийдвэрлэжээ.

Монгол Улс 2018 оны 5-р сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд Монгол улсын хүний эрхийн төлөв байдлын тухай үндэсний тайлангийн хэрэгжилтийн дунд шатны тайлангаа илгээнэ. 2016 оны 4-р сарын 11-ний өдөр батлагдсан Засгийн газрын “Ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 204 тоот тогтоолоор батлагдсан Үйл ажиллагааны төлөвлөгөөнд үзэл бодлоо, илэрхийлэх эрх чөлөөний талаар өгсөн 8 улсын зөвлөмжийг хэрэгжүүлэх 11 арга хэмжээ тусгаснаас 9 нь огт хэрэгжиж эхлээгүй байна. Монголын Засгийн газар 2018 оны үлдэж буй хугацаанд дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана гэдэгт найдаж байна.

2017 онд “Хил хязгааргүй сурвалжлагчид” (RSF) олон улсын байгууллагын Хэвлэл эрх чөлөөний индексээр Монгол Улс дэлхийн 180 орноос 71 дүгээр байрт жагсаж, хэвлэлийн эрх чөлөөний “мэдэгдэхүйц асуудал”-тай орны тоонд багтсан хэвээр байна. Мөн Freedom House байгууллагын судалгаагаар хэвлэлийн хагас эрх чөлөөтэй орон хэвээр байна.

Энэ тайлан та бүхэнд монголын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний ерөнхий дүр зургийг харуулна гэдэгт найдаж байна.

Х.Наранжаргал, Глоб Интернэшнл төвийн тэргүүн

НЭГ. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЗӨРЧИЛ 2005-2017 ОНД

Глоб Интернэшнл Төв нь 2005 оны 10 дугаар сараас хойш Монголын хэвлэл мэдээллийн салбар дахь мэргэжлийн эрхийн зөрчилд мониторинг хийж, жил бүр тухайн оны нэгдсэн тайланг бэлтгэн гаргаж буй. Мониторинг эхлүүлсэн хугацаанаас хойш буюу 2018 оны 4-р сар хүртэлх хугацаанд манай байгууллага сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эрхэд халдсан нийт **701** зөрчил бүртгээд байна. Үүнээс 2017 онд нийт 91 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой мэргэжлийн эрхийн 182 зөрчил бүртгэгдэв. Уг бүртгэл нь Монголын сэтгүүлч, хэвлэл мэдээллийнхний эрхэд халдсан зөрчлийн бүрэн тоо баримт биш гэдгийг анхаарах нь зүйтэй. Эрх нь зөрчигдсөн олон сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл энэ талаар мэдээлэхийг хүсэхгүй байна.

Энэ удаагийн зөрчлийн бүртгэл өнгөрсөн жилүүдийнхээс харьцангуй өндөр гарсан нь 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Зөрчлийн тухай хуулийн “Гүтгэх” хэмээх 6.21 дүгээр зүйлтэй шууд холбоотой юм. Учир нь хууль үйлчилж эхэлснээс хойших есөн сар гаруйн хугацаанд цагдаагийн байгууллагад сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой нийт 95 гомдол иржээ. Үүнийг мониторингийн аргачлалын хүрээнд хэвлэл мэдээллийн эрхийн зөрчил буюу “Шүүх, хүчний байгууллагын дарамт /шүүхэд нэхэмжлэл гаргасан” гэсэн ангилалд шууд тооцон оруулсан болно. Үүн дээр манай байгууллагаас бие даан бүртгэж авсан, нээлттэй асуулгаар ирсэн мэдээллүүдийг нэгтгэсний үндсэн дээр 2017-2018 оны судалгааны дүнг гаргасан билээ.

Нээлттэй асуулгын дүнг ажиглавал, Монголын хэвлэл мэдээллийн салбарт далд нуугдсан олон асуудлыг харж болохын нэг нь редакцийн цензур байв. Тухайлбал, “Таны ажилладаг редакцид хаалтын гэрээтэй эсвэл бусад шалтгаанаар бичихийг хориглосон сэдвийн хар жагсаалт гэж бий юү” гэж асуухад нийт оролцогчдын 40 хувь нь “тийм” гэж хариуллаа.

Мөн “Таны нийтлэл, нэвтрүүлгийг нийтлэгдэх, нэвтрүүлэхээс өмнө хориглосон эсэх” гэж асуухад 23.3 хувь нь “тийм” гэж хариулсан бөгөөд дийлэнх нь хаалтын гэрээ эсвэл редакцийн удирдлагын заавраар нийтлэл, мэдээллээ гаргаж чадаагүйгээ хэлсэн юм. Энэ бүгдээс харвал хэвлэл мэдээллийн салбар дахь хаалтын гэрээ, бизнес улс төрийн ашиг сонирхлын хамаарлаас үүдэлтэй редакцийн цензур хэвшмэл зүйл болж эхэлжээ.

Асуулгын эцэст “Эдгээр зөрчлийн тухай олон нийт эсвэл редакцидаа мэдэгдсэн эсэх” гэж асуухад нийт оролцогчдын 16.6 хувь нь “мэдэгддэг боловч редакциас ямар нэгэн хариу арга хэмжээ авдаггүй” гэж хариулсан байна.

Эрх нь зөрчигдсөн ХМХ-ийн төрлөөр /2017.05 – 2018.05/



Радио, ФМ



Вебсайт



ТВ




Сонин хэвлэл

2017-2018 онд гарсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийг ангилбал:

- Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан - 0 тохиолдол (нийт зөрчлийн 0%)
- Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан - 20 (11%)
- Мэдээлэл өгөхөөс татгалзсан /мэдээлэл олж авах, түгээхэд саад хийсэн –26 (14.3%)
- Ажлын багаж хэрэгсэлд халдсан – 8 (4.4%)
- Шүүх, хүчний байгууллагын дарамт /шүүхэд нэхэмжлэл гаргасан – 108 (59.3%)
- Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан – 11 (6%)
- Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх хэлбэрийн цензур – 9 (5%)
- Түр саатуулагдсан, хоригдсон - 0 (0%)

Зөрчлийн хэлбэрүүд



Зөрчлийн хэлбэр	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Нийт
Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан	3	3	6	-	-	1	5	-	4	5	1	0	28
Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан	16	7	23	13	10	8	5	6	9	12	8	20	137
Мэдээлэл өгөхөөс татгалзсан /мэдээлэл олж авах, түгээхэд саад хийсэн	8	10	13	2	-	7	7	8	11	6	6	26	103
Ажлын багаж хэрэгсэлд халдсан	3	3	2	-	2	2	4	2	2	4	2	8	33
Шүүх, хүчний байгууллагын дарамт /шүүхэд нэхэмжлэл гаргасан	2	8	5	3	5	3	5	6	8	17	17	108	187
Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан	3	1	5	1	6	3	4	11	9	10	4	11	68
Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх хэлбэрийн цензур	2	1	3	1	2	3	9	9	4	11	13	9	65
Түр саатуулагдсан, хоригдсон	4	4	2	0	5	6	6	11	10	12	12	0	72
Амь насаа алдсан	-	-	-	-	-	-	-	1	2	1	-	0	4
Нийт	41	37	59	20	30	33	45	54	59	78	63	182	701



Глоб Интернэшнл төв 2017-2018 онд гарсан сэтгүүлчдийн мэргэжлийн эрхэд халдсан дараах зөрчлийг онцолж байна.

- **Хэвлэл мэдээллийн редакци руу зөвшөөрөлгүй халдлаа**

Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөлтэй дотоодын цөөн хэдэн компанийн нэг болох “Сод Монгол” групп Chuham.mn сайтын редакцид зөвшөөрөлгүй нэвтэрч, сэтгүүлчдийг нь заналхийлэн, нэгжлэг хийж хэвлэлийн эрх чөлөөнд ноцтойгоор халдсан явдлыг Глоб Интернэшнл төвөөс буруушааж байна.

2018 оны нэгдүгээр сарын 26-ны өдөр 18.00 цагийн орчимд “Сод Монгол” группийн хуулийн зөвлөх, компьютерын инженер гэх хоёр хүн, Баянгол дүүргийн 5-р хорооны хэсгийн төлөөлөгч Н.Эрдэнэбилэг нарыг дагуулан тухайн сайтын редакцид шууд нэвтэрчээ. Ингэхдээ нэгжлэг хийх талаар шүүх, прокурорын ямар ч албан ёсны зөвшөөрөл үзүүлэлгүй түрэмгийлэн дайрч, тухайн сайтын админ эрхээр нь архивт нэвтэрч Ц.Анандбазар болон “Сод Монгол” групптэй холбоотой сөрөг мэдээллүүдийг түүж устгахыг шаардсан гэдгийг тухайн мөчид редакцид ажиллаж байсан сэтгүүлчид мэдүүлсэн. Мөн энэ үеэр “Сод Монгол” группийн ажилтнууд нь тус сайтын санхүүгийн тайланг авахыг завдсан төдийгүй сэтгүүлчдийн зургийг авч, байгууллагын компьютер, бусад өмчийг хураан авч явахыг завдсан аж.

Chuham.mn сайтыг эзэмшигч Б.Мөнхдөлийн тайлбарласнаар тус редакци шатахуун импортлогчдын талаарх мэдээллийг цувралаар нийтлэхээр төлөвлөж байсан бөгөөд 2015 онд “Үндэсний шуудан” сонинд нийтлэгдсэн “Сод Монгол” групптэй холбоотой материалыг эргэн сануулах зорилгоор сайтдаа нийтэлсэн нь энэ бүхний шалтгаан болсон гэж үзэж байгаа аж. Болсон явдалтай холбогдуулан Б.Мөнхдөл БГД-ийн цагдаагийн хэлтэс болон зохих ёсны төрийн албан байгууллагуудад хандсан ч тухайн хэсгийн төлөөлөгчийг ёс зүйн алдаа гаргасан гэх шалтгаанаар цалингийн 20 хувиар торгосноос өөр ямар ч арга хэмжээ аваагүй гэж мэдээлсэн юм.

- **Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд эдийн засгийн давхар цензур ногдуулав**

“Өнөөдөр” сонин 2017 оны аравдугаар сарын 27-ны өдрийн дугаартаа иргэдийн гомдлын мөрөөр Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд оршин суугчдын эрүүл мэнд, амьдрах орчинд хор уршиг учруулж, байгаль орчныг доройтуулж буй талаар “Хайлааст багийнхан уух ус, гишгэх газаргүй болоход ойрхон байна” гарчигтай нийтлэл хэвлэжээ.

Уг нийтлэлийн улмаас “Уулс Заамар” ХХК нь 2017 оны арван нэгдүгээр сарын 16-ны өдөр Чингэлтэй дүүргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ, дээрх хэвлэл мэдээллийн байгууллагыг тус компанийн тухай үндэслэлгүй, илт худал мэдээлэл тараасан, мөн ажил хэргийн нэр хүндийг гутааж, их хэмжээний хохирол учруулсан тул няцаалт хийх, уучлалт

гуйхыг даалгаж, ажил хэргийн нэр хүндийг сэргээх, мөн гэм хорын хохиролд 100,000,000 (нэг зуун сая) төгрөг гаргуулахыг шаарджээ.

Гэвч шүүх хурлын тов зарлагдаагүй, тус сонины сурвалжлах багийнхны гэм буруутай эсэх нь тогтоогдоогүй байхад компаниас тус сонины дансны зарлагын хөдөлгөөнийг нэхэмжлэлийн шаардлага болох 100 сая төгрөг хүртэлх мөнгөн дүнгийн хэмжээгээр зогсоох хүсэлт шүүхэд гаргасны дагуу Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч 2018 оны нэгдүгээр сарын 17-ны өдөр тус сонины дансны зарлагыг зогсоох захирамж гаргажээ.

Тус сонины редакци энэ үйлдлийн талаар “Нийтлэлд дурдагдсан баримт бүр нь баттай эх сурвалжаас авсан мэдээлэл бөгөөд үүнийгээ ч бид нотлох болно” гээд “Энэ үйлдэл нь хэвлэн нийтлэх эрхийг эдийн засгийн аргаар боох гэсэн оролдлогын маш тод жишээ болж байна.” гэжээ.

- **УИХ-ын дарга М.Энхболд сэтгүүлч Т.Баасансүрэнг шүүхэд өглөө**

Өргөн нэвтрүүлгийн “ТВ9” телевизийн гүйцэтгэх захирал, сэтгүүл зүйн судлаач доктор Т.Баасансүрэнгийн “Зууны мэдээ” сонины 2018 оны нэгдүгээр сарын 5 болон 9-ны 5710, 5712 тоот дугаарт тус тус хэвлүүлсэн нийтлэлтэй холбогдуулж УИХ-ын дарга М.Энхболд Иргэний хуулийн хүрээнд шүүхэд гомдол гаргалаа.

Доктор Т.Баасансүрэн 2017 оны 7-10 сарын хороонд “Өдрийн сонин”, “Зууны мэдээ”, “Өнөөдөр”, “Монголын мэдээ”, “Улс төрийн тойм”, “Үндэсний шуудан”, “Өглөөний сонин” зэрэг өдөр тутмын 7-8 хэвлэлд Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар хэрхэн бичсэн талаар задлан шинжлэл хийснээ хэвлүүлсэн аж. Тэрбээр 2018 оны нэгдүгээр сарын 5-нд “Зууны мэдээ” сонины “Эрдэмтний үг” буланд “Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны талаарх зарим санал бодол, үр дүн ба сургамж”, 2018 оны нэгдүгээр сарын 9-нд мөн сонины “Баримт, тайлбар” буланд “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны талаарх зарим санал бодол, үр дүн ба сургамж” нийтлэлээ тус хэвлүүлжээ.

УИХ-ын дарга М.Энхболдын хувьд эдгээр нийтлэлтэй холбогдуулж Иргэний хуулийн хүрээнд нэр төрөө сэргээлгэхээр Сүхбаатар дүүргийн шүүхэд гомдол гаргасан байна. Гомдлын дагуу шүүх хурал 2018 оны 3-р сарын 28-ны 09.00 цагт Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн шүүхэд болж, УИХ-ын дарга М.Энхболдын нэхэмжлэлтэй нэр төрд халдсан гэх хэргийг буцаах шийдвэр гаргасан аж. Учир нь шүүхээс зарласан цагт нэхэмжлэгч талаас итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нар ирээгүй тул хуулийн байгууллагад хүндэтгэлгүй хандсан гэсэн үндэслэлээр хэргийг буцаасан байна.

Ноцтой мэдэгдэл

Нэр бүхий есөн сэтгүүлч болон тэдний ар гэрийн 30 хүний мэдээллийг хууль бусаар олж аван тагнаж, чагнасан гэх мэдээлэл 2018 оны 4-р сарын 26-нд нийтэд ил болов. Энэ хэрэгт холбогдуулан Тагнуулын ерөнхий газраас зохих албан тушаалтнуудад эрүүгийн хэрэг үүсгүүлэх хүсэлтээ ч Нийслэлийн прокурорын газарт албан ёсоор хүргүүлсэн байна. Энэ талаар Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Г.Бясман “Цагдаагийн байгууллагын нэр бүхий албан тушаалтнууд хамтарч Гүйцэтгэх ажлын хууль тогтоомж зөрчиж, нэр бүхий сэтгүүлч, хувь хүнийг тагнаж, чагнасан гэх асуудлыг ТЕГ-ын Мөрдөн шалгах хэлтсээс шалгаж, цагдаагийнханд эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татах саналаа манайд ирүүлсэн. Прокурор энэ хэргийг хянаж байна” гэсэн хариулт өгөөд байна. Энэ нь Монголд хэвлэлийн эрх чөлөө, цаашлаад Үндсэн Хуулиар олгогдсон хүний халдашгүй дархан байх эрх зөрчигдөж буйн илрэл тул дээрх хэргийг цаг алдалгүй, олон нийтэд нээлттэйгээр шалган шийдвэрлэх ёстой гэж Глоб Интернэшнл төв үзэж байна.

ХОЁР. СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭСРЭГ ИРГЭНИЙ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

Глоб Интернэшнл Төв нь улсын хэмжээнд 2017 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан иргэний хэрэг, маргаан, бусдыг гүтгэсэн, доромжилсон эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдлыг судлан, Иргэний болон Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтыг улс төрчид, төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага хэрхэн ашиглаж буйд судалгаа хийв. Хэдийгээр хүчингүй болсон ч Эрүүгийн хуулийн 111.2 дугаар заалт болох Гүтгэх, доромжлох зүйл ангийн үйлчлэх хугацааг шинэ хууль хэрэгжих хүртэл буюу 2017 оны 7 дугаар сарын нэгний өдрийг хүртэлх хугацаагаар зааглаж үзсэн.

Монгол Улсын Иргэний хуулийн 21, 27, 497, 511 дүгээр зүйлүүдэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, учирсан гэм хорын хохирлыг арилгах, Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж хуульчилсан. 2017 онд Монгол Улсын хэмжээнд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбогдох иргэний 49 хэрэгшийдвэрлэснээс 12 нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой байна. Эдгээрээс шүүхээр шийдвэрлэсэн 12 хэрэгтэй танилцах боломжтой байв.

Нэхэмжлэл гаргагчдын 33% нь төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага байна. Шүүхийн шийдвэрийн төрлийг авч үзвэл, нэр төр, ажил хэргийн нэр хүнд гутаагдсаныг сэргээж, мэдээг тараасан хэлбэр, хэрэгслээр няцаалт хийж, залруулга гаргахыг даалгасан 7, талуудын эвлэрлийг баталсан 4, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 1 шийдвэр байна..

2017 онд эдийн бус гэм хорын хохиролд олны танил улс төрч хэвлэл мэдээллийн хэрэгслээс 75 сая төгрөг нэхэмжилсэн боловч анхан шатны шүүхээс түүний нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ. Нэхэмжилсэн мөнгөн дүнгийн дээд хэмжээ 104,7 сая төгрөг байгаа нь 2016 онтой харьцуулахад 50 гаруй сая төгрөгөөр буурчээ. Шүүхийн шийдвэрээр хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн мөнгөн дүнгийн дээд хэмжээ 2 сая төгрөг байсан бөгөөд энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад адил дүнтэй байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрээр хэргийн 6 буюу 50% нь нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон бол гэм буруутай гэж үзсэн 3 хэрэг байна.

Нэхэмжлэгч, хариуцагч хоорондоо эвлэрсэн 3 хэрэг байна.

1999-2017 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, гүтгэлэг, доромжлолтой холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн нийт иргэний болон эрүүгийн **848** хэргийн **426** буюу **50.2%** нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох хэрэг байна.

Судалгааг shuukh.mn цахим хуудасны мэдээлэлд үндэслэн хийв.

1999-2017 оны хэргийн харьцуулсан үзүүлэлт

Он	Иргэний хэрэг		Эрүүгийн хэрэг	
	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах
1999	30	-	3	-
2000	39	-	-	-
2001	31	11	4	-
2002	44	37	2	2
2003	28	18	1	1
2004	40	40	1	1
2005	29	25	1	1
2006	36	31	3	3
2007	33	33	-	-
2008	39	25	5	5
2009	44	17	1	-
2010	67	37	2	-
2011	43	23	7	3
2012	43	20	8	4
2013	37	17	9	3
2014	45	20	12	9
2015	37	10	14	5
2016	47	12	9	1
2017	49	12	5	0
Нийт	761	388	87	38

3.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа

Үндсэн хууль ба олон улсын эрх зүйн хэм хэмжээ

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Хүний эрх, эрх чөлөө бүлгийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ хэмээн заасан. Үүнд:

16.16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.

16.17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

Монгол Улс НҮБ-д 1961 онд гишүүнээр элсэн орсон бөгөөд гишүүн орны хувьд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг соёрхон баталж, 2012 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элссэн. Тиймээс олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй. Энэ үүргийг Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан. Эдгээр олон улсын гэрээ конвенци 2004 оны “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаарт монгол хэлнээ албан ёсоор хэвлэгдсэн.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17 дахь хэсэгт “Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” хэмээн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тавьж болох зорилго, үндэслэлийг заасан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэж заасан. Итгэл үнэмшилтэй байвч түүнийгээ илэрхийлэх арга хэрэгсэлгүй бол энэ эрх хэрэгжих боломжгүй юм.

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарим хязгаарлалтыг Үндсэн хуулийн үзэл баримтлал болон олон улсын гэрээ конвенцийг удирдлага болгож, Гурван талт шалгуур /Three part test/-ыг бүрэн хангасан үед л зөвхөн хүлээн зөвшөөрөх ёстой. Үүнд:

Нэгдүгээрт. Гагцхүү хуулиар тогтоох

Хоёрдугаарт. Хязгаарлалт нь хууль ёсны зорилготой байх

Гуравдугаарт. Зайлшгүй буюу гарцаагүй байх, хэмжээндээ байх

Үүнээс өөрөөр хязгаарлалт хийхийг хүлээн зөвшөөрөх ёсгүй ч, илүүц, хүний язгуур эрхийг зөрчсөн хязгаарлалт хууль тогтоомжид тусгагдах, эсвэл практикт хэрэглэсээр байна. 2011 оны 7 дугаар сарын 11-29-ний өдрүүдэд Женев хотноо болсон НҮБ-ын Хүний эрхийн хорооны 102 дугаар чуулганаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд 34 тоот Ерөнхий тайлбарыг Монгол Улс албан ёсоор орчуулж, практикт хэрэглэж хэвших, таниулах шаардлагатай байна.

3.2. Хэвлэлийн эрх чөлөө ба сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа

1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2, 3, 4 дүгээр зүйлд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргах болон төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх, төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг тус тус хориглосон нь хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан суурь зохицуулалт болдог.

Улсын Дээд Шүүх (УДШ)-ийн тайлбарт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэдгийг “Зар сурталчилгааны тухай” хуулийн 3 дугаар бүлэгт 3.1.5 дахь хэсэгт “Мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерийн сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгсэл” гэсэн утгаар ойлгоно хэмээн тогтоосон.

УИХ-аас 2005 оны 1 дүгээр сарын 27-нд “Олон нийтийн радио, телевизийн тухай” хууль баталснаар үндэсний хэмжээнд олон нийтэд үйлчлэх, түүний хяналт санхүүжилтэд байх статус бүхий телевиз, радиогийн эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Түүнээс хойш хэвлэл мэдээллийн салбарт шаардлагатай байгаа өргөн нэвтрүүлгийн ерөнхий хууль, сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах, мэдээлэгчийг хамгаалах, салбар дахь шударга өрсөлдөөн, өмчлөлийн ил тод байдлыг хангах тухай эрх зүйн зохицуулалт хийгдээгүй.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн шинэчилсэн найруулгын хэд хэдэн төсөл боловсрогдсон ч, УИХ-аар хэлэлцүүлж батлуулаагүй байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд² “Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ”(3.3.3.2) гэж заажээ. Түүнчлэн “хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана”(3.3.4.3) гэж заасан байдаг.

2015 онд Монгол хэлний тухай хууль баталж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага нь “монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах”, “сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны мэргэжлийн ур чадварын шалгалтад монгол хэл, бичгийн мэдлэгийн шалгуур тогтоосон байх” /19-р зүйл/ үүрэг хүлээлгэсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага монгол хэлний хэм хэмжээг баримталж байгаа эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах /21.7.9/ чиг үүрэгтэй ажиллана.

3.3. Мэдээллийн эрх чөлөө ба хязгаарлалт

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.17 дугаар зүйлд мэдээлэл “хайх, хүлээн авах” эрхийг хамгаалдаг бөгөөд мэдээлэл “түгээх” эрхийн тухай үгчлэн оруулаагүй хэдий ч өмнө дурдсан олон улсын гэрээ конвенцийн дагуу “хил хязгаар үл харгалзан”³ мэдээлэл “хайх, хүлээн авах болон түгээх” эрх баталгаажсан гэж үздэг.

2005 онд батлагдсан Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 34.1 зүйлд “Олон нийтийн радио, телевизийн ажилтан төр, байгууллага болон хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг олж авах, нийтийн хүртээл болгох эрхтэй” гэж МҮОНРТ-ийн сэтгүүлчдийн эрхийг баталгаажуулсан. Харин 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай (МИТБМАЭ) хууль батлагдсанаар мэдээлэл олж авах эрхээ эдлэх боломж, нөхцөл хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид төдийгүй иргэдэд бүрдсэн билээ.

Энэ хуулийн 6 дугаар зүйлд үйл ажиллагаа, төсөв, санхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны мэдээллийг нээлттэй байлгах үүргийг төрийн байгууллагуудад ногдуулсан. Аливаа иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагаас хүссэн хэлбэрээрээ мэдээлэл авах хүсэлт гаргах эрхтэй бөгөөд төрийн албан хаагчид хүсэлтийн хариуг дээд тал нь ажлын 7 хоногийн дотор, зайлшгүй тохиолдолд ажлын 14 хоногт өгөх үүрэгтэй.Хариуг нь шууд өгөх боломжтой хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж хариу өгнө. Түүнчлэн энэ хуулийн хэрэгжилтийг шалгах зорилгоор тэмдэглэл хөтлөх /23-р

²“Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2010 оны №36

³ИБУТЭТОУП-ын 19-р зүйл (2)

зүйл/, энэхүү тэмдэглэл нь үр дүнгийн гэрээг үнэлэх шалгуур үзүүлэлт болгох /24-р зүйл/-оор заасан нь хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих зохицуулалт бий.

Мөн хуулийн 18 дугаар зүйлд заасан өгөхийг хориглосон мэдээллийн төрөл нь хэт ерөнхий, өргөн хүрээг хамарч байна. Үүнд: (1) тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэл байгаа, (2) тухайн мэдээлэл нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хянан шалгагдаж байгаа асуудалтай холбоотой, (3) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай зэрэг тохиолдол орно. Түүнчлэн уг хууль нь оюуны өмч, хувь хүний нууц болон байгууллагын нууцыг хамгаалдаг. Уг хуулийн 17 дугаар зүйлд эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд дээд албан тушаалтан, дээд шатны байгууллага болон Хүний Эрхийн Үндэсний Комисс, Захиргааны шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

Уг хуулийн дагуу Засгийн газраас 2013 оны 1 дүгээр сард “Мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам”, 12 дугаар сард “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ыг тус тус баталсан.

МИТБМАЭ-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйл “Төсөв, санхүүгийн ил тод байдал”, 10 дугаар зүйл “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал” заалтуудыг хүчингүй болгож, Шилэн дансны тухай хуулиар зохицуулж байна. Шилэн дансны хуулиар зохицуулахгүй бусад төсөв, худалдан авах ажиллагаатай холбоотой зохицуулалт нь хүчин төгөлдөр үйлчлэх юм.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийтийн албан тушаалтнууд ашиг сонирхлын мэдүүлгээ, Авлигын эсрэг хуулиар өөрийн болон гэр бүлийнхээ хөрөнгө, орлого, зээлийг мэдүүлэх үүрэг хүлээсэн тул энэ төрлийн мэдээлэл нээлттэй болж байна.

2016 онд батлагдсан Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Хөгжлийн банкны тухай хууль, Барилгын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хуульд МИТБМАЭ-ийн тухай хуульд нийцүүлэн олон нийтэд ил тод, нээлттэй, олон нийтэд мэдээлэх зарчмыг зүйлчилсэн байна. Мөн ил тод, нээлттэй байх үүргийн хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг заавал байлцуулах, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр заавал түгээх тухай хуулийн заалтууд шинээр батлагджээ. Тухайлбал, 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт “Хэсэгт санал тоолох ажиллагааг санал асуулга явуулах өдрийн 22.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл

мэдээллийн болон иргэний төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна” гэжээ. Мөн 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Нийтийн сонсголын тухай хуулийн “Сонсголын нийтлэг журам” хэмээх 18 дугаар зүйлийн нэг дэх хэсгээр “Нээлттэй сонсголд хэвлэл мэдээллийн төлөөллийг заавал оролцуулах” үүрэг хүлээлгэжээ.

2016 оны 12 дугаар сарын нэгний өдөр УИХ-аас “Төрийн ба албаны нууцын тухай хууль”-ийг УИХ-аар баталсан ба үүнтэй холбогдуулан Төрийннууцынжагсаалтбатлахтухай хууль, Байгууллагыннууцын тухай хуулийг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгож, төрийн байгууллагын албаны нууцтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулдаг болжээ. Шинэ хуулиар мэдээлэл нууцлах хугацаа 60 жилээс 30 жил болж, багассан байна.

Гэвч шинэ хуульд орсон зарим зохицуулалт анхаарал татаж байна. Тухайлбал, уг хуулийн “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт” хэмээх 5 дугаар зүйлийн 5.1.2-т “албаны нууц гэж задруулах, үрэгдүүлэх, тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээлэл” гэж тодорхойлжээ. Энэ нь олон нийтийн эрх ашгаас дээгүүр, МИТБМАЭ-ийн тухай хуулийн үзэл баримтлал, зарчимтай зөрчилдсөн гэж болохоор байна.

Мөн шинэ хуулиар төрийн нууцад хамаарах мэдээллийн хүрээг “төрийн бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажил, мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд” хэмээн тогтоосон нь хэт өргөн хэвээр байна. Түүнчлэн, хуулийн 10 дугаарзүйлийн 10.1.5-д мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудал нь Засгийн газрын бүрэн эрхэд хамаарахаар хуульчилжээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн Хуулийн төр, байгууллагын нууцыг хуулиар тогтоон хамгаалах тухай заалттай нийцэж байгаа нь эргэлзээтэй.

2017 оны 6 дугаар сард Засгийн газраас МИТБМАЭ-ийн тухай хуулийг үндэслэн “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг баталсан нь иргэдэд төрийн мэдээллийг шуурхай, чирэгдэлгүйгээр хүргэхэд тодорхой ахиц авчирна гэж найдаж байна. Тодруулбал, тус журмын хүрээнд Тагнуулын ерөнхий газар төрийн цахим мэдээлэл солилцооны системээр солилцох төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг гаргахаар заасан байна. Мөн Үндэсний дата төв нь иргэдэд үйлчилгээ үзүүлэх төрийн нэгдсэн үйлчилгээний порталын хөгжүүлж иргэн, байгууллагад үйлчлэх цахим үйлчилгээний нэр төрөл, тодорхойлолтыг нийтэд мэдээлэхээр тусгажээ.

3.4. Сонгууль ба хэвлэл мэдээлэл

Ардчилсан сонгуульд хэвлэл мэдээлэл үзэл бодлын чөлөөт индэр болж, нэр дэвшигч, улс төрийн нам, эвслийн байр суурийг олон нийтэд ойлгуулах, зөв сонголт хийхэд тусладаг чухал үүрэгтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл /ХМХ/ нь иргэдэд сонгуулийн үйл явцын талаар нэг талыг бариагүй, туйлшраагүй мэдээлэл түгээх үүрэгтэй. Өрсөлдөгч нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, үзэл бодол, хэтийн төлөвлөгөө, ирээдүйг харах чадвар зэргийг тайлбарлан таниулах үүргийг хэвлэл мэдээлэл чухам сонгуулийн үеэр л гүйцэтгэдэг.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зарчмын дагуу сэтгүүлч, редактор, продюсер, ХМХ-ийн эзэд өөрсдийн түгээж буй мэдээллийн агуулга, хэлбэр, гарах үр дагаврыг хариуцах үүрэгтэй. Сонгуулийн мэдээллийг нийтэлж, нэвтрүүлэхдээ аливаа айлган сүрдүүлэлт, хязгаарлалт, ялгаварлал, цагдан хяналтгүйгээр бодит мэдээллийг олж авах, түгээх эрхийг төрөөс баталгаажуулах ёстой. Төрийн эрх мэдэлтнүүд сонгуульд нөлөөлөх зорилгоор сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнуудын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох ёсгүй. ХМХ-ийн менежер, эзэд сэтгүүлчийн ёс зүй, хараат бус байдлын зарчмыг хүлээн зөвшөөрч, ажилтнууддаа эдгээр зарчмаас гажихад хүргэх дарамт үзүүлэх ёсгүй юм. Ялангуяа өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл онцгой хариуцлагатай мэдээлэх үүрэгтэй.

Өнөөдөр Монголд 500 шахам хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс орон даяар үйл ажиллагаа явуулж буй өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл 300 шахам байгаагаас зөвхөн Улаанбаатар хотод телевизийн дал гаруй суваг байгаа юм.

Глоб Интернэшнл төв нь 2017 оны МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлэг эрхэлдэг таван телевизийн сонгуулийн сурталчилгаанд мониторинг хийсэн. Тус мониторингийг Нээлттэй Нийгэм Форумын санаачилгаар байгуулагдсан “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-ний хүрээнд дөрөв дэх удаа хийсэн юм.

Мониторингид ““МҮОНТ””, “TV9”, “25 дугаар суваг”, “С1”, “UBS” гэсэн 5 телевизийг хамруулахаар сонгов. Дээрх телевизүүдийг сонгохдоо Хэвлэлийн хүрээлэн, Максима ХХК-ны 2016 оны судалгаанд суурилж, олон нийтийн санхүүжилт ашигладаг, хамгийн хүртээмжтэй, орон даяар цацагддаг, агаарын долгион ашигладаг, үзэгчдийн тоо, рейтинг өндөр, цаг үеийн мэдээний хөтөлбөр нэвтрүүлдэг, зах зээлд 4-өөс дээш жил оршин тогтносон, нэр дэвшигчийн хамаарал зэрэг шалгуурыг үндэслэв.

Мониторингийн ерөнхий дүнгээс харахад, телевизүүд МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн кампанит ажлын үеэр тэнцвэртэй, шударга бус байж, нэр дэвшигчдийн тухай мэдээлэлд хэт нэг талыг барьж, туйлширсан байдал ихээр ажиглагдаж өмнөх сонгуулиудын алдааг давтсан. Далд сурталчилгааны шинжтэй мэдээлэл ихээр нэвтрүүлж, мэдээний хөтөлбөр нь нам, эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгаа болон хувирсан, хуульд заасан сурталчилгааны цагийн хязгаарыг хэтрүүлсэн зэрэг өмнөх сонгуулиудын сурталчилгааны явцад гарч байсан зөрчлүүд мөн давтагдсан байна. Сонгуулийн тухай хуулийн 82.14 дэх заалтыг ашиглан цаг үеийн мэдээ мэдээллийн хөтөлбөрийг далд сурталчилгааны талбар болгон ашиглах явдал ихээр ажиглагдав.

Сонгуулийн тухай хууль

2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр тусдаа байсан хэд хэдэн сонгуулийн хуулийг нэгтгэн, Сонгуулийн тухай хууль шинээр батласан билээ. Энэ хуулийн “Сонгуулийн сурталчилгаа” гэсэн 9 дүгээр бүлэг нь бүхэлдээ нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, түүний агуулгын хяналт, хэвлэмэл болон радио телевиз, цахим орчноор мэдээлэл түгээхтэй холбогдсон зохицуулалтыг оруулсан.

Хуулийн 68.3 дахь зүйлд сонгуулийн сурталчилгааны арга хэлбэрийг тусгайлан зохицуулж, үүнд сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах /§68.3.1/, радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах /§68.3.6/, цахим хуудас ашиглах /§68.3.7/ тухай заасан.

Сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт “Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс хорь хоногийн өмнө эхлүүлж, санал авах өдрөөс нэг хоногийн өмнө дуусгана”, 68.6 дахь хэсэгт “Сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00.00 цагаас өмнө зогсооно”, 68.3.6 дахь хэсэгт сонгуулийн сурталчилгааны арга, хэлбэрийн нэг нь “радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах” гэдгийг тодорхойлж, 68.7 дахь хэсэгт Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын доод хэсэгт захиалсан этгээдийн эх сурвалжийг заавал дурдаж, захиалагчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих ба энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарах ба радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд захиалагчийн нэрийг дурдана хэмээн заасан.

Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах нарийвчилсан зохицуулалтыг 82 дугаар зүйлд заасан.

Олон нийтийн радио, телевиз нь сурталчилгааны нэвтрүүлгийг сонгуулийн төв байгууллагаас сонгуульд оролцогч нам, эвсэл тус бүрээрижил нөхцөл, боломж, тэнцүү хугацаа ногдохоор тооцож, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс таваас доошгүй хоногийн өмнө баталсан хуваарь, цагийн дагуу зөвхөн үнэ төлбөргүй нэвтрүүлнэ хэмээн зохицуулав.

Сонгуулийн энэ шинэ хуулиар УИХ-ын болон орон нутгийн сонгуульд хувь нэр дэвшигчид тэнцүү цаг хуваарилахгүй бөгөөд үүнийг сонгуульд оролцогч улс төрийн нам, эвсэл дагаж мөрдөнө гэж заасан бол Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд нэр дэвшигч тус бүрт тэнцүү цаг хуваарилахаар зохицуулсан. Түүнчлэн ижил цаг олгох нь ижил тэгш нөхцөл, ижил боломж олгох хуулийн шаардлагууд юм. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз нь сурталчилгааны нэвтрүүлгийг гэрээний үндсэн дээр нэвтрүүлнэ. Сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт нэг цаг /60 минут/-аас илүүгүй байна. Сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвсэл түүнчлэн нэг нэр дэвшигчид ногдоно.

Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлд хууль бус сурталчилгааг хориглосон бөгөөд хэвлэл мэдээллийн хориглосон үйл ажиллагаа нь:

- хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орон зай, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулах, бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах /§70.1.6/;
- Аливаа этгээд санал авах өдөр хүртэлх долоо хоногийн хугацаанд нам, нэр дэвшигчдийн талаар санал асуулга явуулах, энэ төрлийн мэдээллийг бүх төрлийн мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтлэх, тараахыг хориглоно. §70.2/;
- сонгуульд оролцохоос татгалзах, сонгуулийн болон бусад хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах /§70.5.7/;
- сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг, материалд шашны холбогдолтой аливаа дуу, зураг хэвлэх, нийтлэх, нэвтрүүлэх /§70.5.9/;
- сонгуулийн сурталчилгааны явцад бусдыг гүтгэх, доромжлох, гутаах, хуурамч мэдээ, мэдээллийг төрөл бүрийн хэлбэрээр тараах /§70.5.13/;
- Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр сонгуульд оролцогч аль нэг талын талаар бүх төрлийн мэдээ, мэдээлэл гаргах, гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно /§70.7/

Эндээс дүгнэхэд хуулийн 70.1.6 болон 70.2 дахь заалт нэг нь нөгөөтэйгөө зөрчилдсөн мэт эргэлзээг төрүүлж байна.

Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл заалтыг зөрчсөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хариуцлага хүлээлгэнэ. Тухайлбал,

- Сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар хуурамч буюу худал мэдээ, мэдээлэл тараасан, нийтэлсэн, цацсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдвол сонгуульд зарцуулсан хөрөнгийг нь гэм буруутай этгээд нөхөн төлнө /§70.8/
- Хуулийн §70.1.6-д заасныг зөрчсөн цахим хуудасны хандалтыг шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо зургаан сарын хугацаагаар түдгэлзүүлнэ /§70.18/
- Радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд Харилцаа холбооны зохицуулах хороо хяналт тавьж ажиллах ба энэ хуульд заасан зөрчил гаргахгүй байх, гарсан зөрчлийг нэн даруй зогсоох арга хэмжээг цагдаагийн болон сонгуулийн

байгууллага, мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно /§82.18/.

- Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх энэ хуульд заасан журам зөрчсөн радио, телевизэд нэг удаа сануулах арга хэмжээ авах бөгөөд дахин давтвал санал авах өдөр хүртэл үйл ажиллагааг нь тухайн зөвшөөрлийг олгосон байгууллага зогсооно /§82.19/.
- Энэ хуулийн тодорхой заалтуудыг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хорооны дүгнэлтийг үндэслэн тухайн зөвшөөрөл олгосон байгууллага зөрчил гарсан өдрөөс эхлэн зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ /§82.21/
- Зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, аливаа этгээдийг олж тогтоох боломжгүй бол Харилцаа холбооны зохицуулах хороо тухайн цахим хуудасны Монгол Улсаас хандах хандалтыг сонгуулийн санал хураалтын хугацаа дуустал хязгаарлана /§83.7/
- Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журмыг сонгуулийн төв байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран энэ хуульд нийцүүлэн баталж, мөрдүүлнэ /§82.17/.

Дээрх зохицуулалтын хувьд ХХЗХ нь засгийн газрын агентлагийн бүтцэд орж байгаа өнөөгийн нөхцөл болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрыг оролцуулж байгаа нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн аливаа хэлбэрийн цагдан хяналт тавихыг хориглосон заалттай зөрчилдөж, хэвлэл мэдээлэлд төрийн цагдан хяналт тогтоож байна.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар сонгуулийн үеэр орон тооны бус Хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулж ажиллахыг үүрэг болгосон. “Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хэвлэл, мэдээллийн мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл болон сонгуульд оролцож буй нам, эвслийн тэгш төлөөллөөс бүрдсэн байна”/14.2/, “Хэвлэл мэдээллийн зөвлөл нь нам, эвсэл, нэр дэвшигчийн хэвлэл мэдээллийн сурталчилгааны тэнцвэрт байдалд хяналт тавих бөгөөд энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, хуулийн этгээд, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, санал дүгнэлт гаргаж Хороонд танилцуулах чиг үүрэгтэй” /14.3/ байхаар хуульчилсан ч тухайн сонгуулийн зохион байгуулалтыг нарийвчлан зохицуулсан хуулиудад хяналт мониторинг болон хэвлэл мэдээллийн эсрэг гаргасан гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх үүргийг ШӨХТГ, ХХЗХ зэрэг төрийн байгууллагуудад олгосон нь давхардлыг бий болгож, өөрийн зохицуулалтын дээрх механизмыг сулруулах нөлөө үзүүлсэн. Харин 2016 оны УИХ-ын болоод МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн үеэр тус зөвлөлийг байгуулаагүй нь СЕХ-ноос хуульд заасан үүргээ биелүүлээгүй зөрчил болж байна.

3.5. Нэр төр гутаахтай холбоотой зохицуулалт

Одоогоор Монгол Улсад иргэний нэр төрийг Иргэний хууль болон Зөрчлийн тухай хуулиар хамгаалж байна. 2017 оны 7 дугаар сарын 1-ээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар “Нэр төр гутаах” гэсэн бие даасан зүйлийг хассан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалахад гарсан ахиц юм. Гэсэн хэдий ч Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 11.2 дугаар заалтад “...нэр төр, алдар хүндийг нь гутаан доромжилсон... улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж сэтгэцийн хэвийн байдал алдагдсаны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” хэмээн заасан нь нэр нөлөө бүхий хүмүүс сэтгүүлчдийн эсрэг цензур болгон ашиглаж болзошгүй гэсэн болгоомжлол төрүүлж байна.

УИХ-аас 2017 оны тавдугаар сарын 11-ний өдөр Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль баталж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон билээ. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 6.21 дүгээр зүйлээр хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд, дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан хувь хүн, хуулийн этгээдийг торгох шийтгэл ногдуулахаар хуульчилсан.

Зөрчлийн тухай хууль үйлчилж эхэлснээс хойш 2018 оны 3 дугаар сарын 20-ны байдлаар гүтгэх зөрчлийн талаарх 230 гомдлыг хүлээн авч, 49 иргэнийг гүтгэх зөрчил үйлдсэн гэж цагдаагийн байгууллагаас нийт 98,000,000 төгрөгөөр торгожээ. Түүнчлэн 6 иргэн шүүхэд гомдол гаргаснаас 3 хүний гомдлыг хангаж, шийтгэлээс чөлөөлсөн байна. Энэ нь Зөрчлийн тухай хууль нь шүүмжлэл болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах зорилгоор ашиглагдах эрсдэлтэй байгааг харуулж байна.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлд зааснаар “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй”. Мөн хуулийн 511 дүгээр зүйлд зааснаар “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ”.

Нэр төр сэргээлгэх тухай Иргэний хуулийн зохицуулалтын нэг асуудалтай тал нь нийтийн албанд хамаарах байгууллагад нэр төр сэргээх боломж олгодогт байна. Өөр нэг тулгамдсан асуудал нь, Иргэний хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил

хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан бол түүнийхээ “бодитой”, “үнэн зөв” гэдгийг нотлохыг мэдээ тараагчид ногдуулсан.

3.6. Агуулгын хязгаарлалт

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх, Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай зэрэг олон хуульд агуулгын хязгаарлалтыг тогтоосон. Эдгээр хязгаарлалт нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хийгдсэнийг бид хүлээн зөвшөөрч байгаа боловч нэр томъёоны хувьд ерөнхий, тодорхойлолт байхгүй, хамрах хүрээг тогтоогоогүй нь хэтрүүлэн ашиглах нөхцөл үүсгэж болзошгүй бөгөөд шүүмжлэл өрнүүлсэн сэтгүүлчдэд халгаатай заалт болж байна.

2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн “Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал” хэмээх 8 дугаар зүйлээр хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаалах, хүүхэд хамгаалах зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах зохицуулалт орсон нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн нийгмийн дэг журмыг хангах үүднээс хуулиар тогтоосон, зайлшгүй хязгаарлалтын тухай заалтад нийцэж байна.

ХХЗХ нь 2011 онд баталж, 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”, “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-аар тогтоосон хэм хэмжээ нь шинжийн хувьд авч үзвэл гадагш чиглэсэн, заавал дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоосон тул Захиргааны хэм хэмжээний актууд юм. Гэсэн хэдий ч эдгээр хэм хэмжээнд Хууль зүйн яамны нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй байна. Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журамд зааснаар “улсын бүртгэлд бүртгэгдээгүй шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж үзэж тухайн шийдвэрийг биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага хүлээлгэхгүй” тухай заасан.

Гэсэн хэдий ч нөхцөл шаардлагуудыг хүчин төгөлдөр мөрдөхийг шаардан, радио телевиз, цахим хуудасны агуулгад хяналт тавьж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хандалтыг хаах зэрэгт үндэслэл болгон хэрэглэсээр байна.

Одоогоор сонин хэвлэлийн агуулгын зохицуулагч байхгүй. Радио, телевизийн хувьд “нийтийн эрх ашгийг” дээдлэх (5.1) үүрэг ногдуулж, долоо хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 50-иас доошгүй хувь нь Монгол Улсад бүтээгдсэн, эсхүл Монгол Улсын иргэн, Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн бүтээсэн нэвтрүүлэг” (5.4) байхаар заажээ.

Сүүлийн үед УИХ-аас батлагдан гарч буй хууль, хэлэлцүүлгийн шатанд яваа хуулийн төслүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үүрэг ногдуулах, илүүц хязгаарлалт, хориг тавих, үүгээр дамжуулан төрийн байгууллагууд цагдан хяналт тогтоох эрсдэл нэмэгдэх хандлагатай байна.

Тухайлбал, Соёлын тухай хуульд 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлтөөр “Соёлын хүрээнд төрийн болон бусад байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт” гэсэн (19) зүйлд нэмэлт оруулсан. Энэ зохицуулалтын гол агуулга нь үндэсний нэвтрүүлгийг дэмжих төрийн бодлоготой уялдаж байгаа ч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт учруулж болзошгүй үүрэг ногдуулалт юм.

3.7. Бусад зохицуулалт

Хэвлэл мэдээллийн өмчлөл ба төвлөрөл

Монгол Улсад бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүртгэлтэй байх ёстой бөгөөд байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор бүртгүүлэх өргөдлөө гаргах үүрэгтэй. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх нь зүйн хэрэг. Гэсэн хэдий ч практикт бүртгүүлэх бичиг баримтын шаардлагад төрийн бус байгууллагын дүрэмд тавих шаардлагыг тавьж байгаа нь ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдийн үйл ажиллагааны зарчмыг хольж байна. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.1 зүйлд заасны дагуу радио, телевизийн байгууллага нь зөвхөн тусгай зөвшөөрөл авсны дараа бүртгүүлэх ёстой. Харин тусгай зөвшөөрөл авахын тулд тухайн засаг захиргааны Засаг даргын саналыг авах шаардлагатай.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл олон төрөлтэй хэдий ч хуульд өмчлөлийн олон талт байдлыг тусгаагүй. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бодлого, зохицуулалтын аль ч түвшинд хүлээн зөвшөөрөөгүй байна.

2010 онд батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх” заалт анх удаа тусгагдсан юм.

УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигч болон орлогын тухай мэдээллийг ил болгоно; хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлнэ; хэвлэл нийтлэх эрх чөлөөг баталгаажуулна” хэмээн заажээ.

ХХЗХ-ны 2015 оны 15 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж баталсан “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын “Эзэмшлийн ил тод байдал” гэсэн 5 дугаар бүлэгт “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өргөн нэвтрүүлгийн хараат бус байдлыг хангах, нээлттэй, ёс зүйтэй байдлыг эрхэмлэх зорилгоор тусгай зөвшөөрлийг олон нийтэд ил тод байлгана. Хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, удирдлагын эзэмшлийн хувь хэмжээ, тусгай зөвшөөрөл

эзэмшигчийн нэр, дэлгэрэнгүй хаяг, харилцах утас, хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, удирдах ажилтнуудын иргэншлийн тухай мэдээллийг жил бүрийн I улиралд багтаан Зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэх”-ээр тусгасан.

Хэвлэл мэдээллийн эзэмшил, харьяалал нь компани, хувь хүмүүсийн өөр өөр нэр дээр бүртгэгдсэн тул жинхэнэ эзэмшигчид нь ил тод бус, борлуулалтын мэдээлэл болон хэрэглэгчдийн зах зээлд эзлэх хувийг нууцалдаг учир төвлөрлийг бодитоор тогтоох боломж хомс байна.

2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь хэсэгт хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авахаар зохицуулсан.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд төрийн өмчлөлийг хориглосон ч сүүлийн жилүүдэд орон нутгийн засаг захиргаа үйл ажиллагаа, бодлогоо сурталчлах телевиз, сонин олноор байгуулж, хууль зөрчиж байна.Хэвлэл мэдээллийн өмчлөл нууц байх, хэвлэл мэдээлэл нэг гарт төвлөрөх нь редакцийн цензурыг өөгшүүлж, ингэснээр хэвлэлийн эрх чөлөөг боогдуулан, олон ургальч үзлийг сааруулж, сэтгүүл зүйн мэдээллийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

Хэвлэл мэдээллийн зах зээл бүрэн төлөвшөөгүй, хэвлэл мэдээллийн байгууллагууд зар сурталчилгааны орлогын төлөө шударга өрсөлдөхөөсөө илүү төрийн байгууллага, улс төр, бизнесийн байгууллагатай гэрээ хийн, үйл ажиллагаа явуулж байна.

Өргөн нэвтрүүлэг

Монголд өргөн нэвтрүүлгийн бие даасан хууль батлагдаагүй хэвээрээ байна.

Олон улсын жишгээр хэвлэл мэдээллийн салбарыг зохицуулах байгууллага нь Засгийн газраас хараат бус байж, давтамжийн зурвас хуваарилалтыг зохицуулах ёстой.“Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлд үндэслэн зохицуулах байгууллага буюу Харилцаа холбооны зохицуулах хороог 1995 онд байгуулсан.Радио долгионы тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Радио долгион нь Монгол Улсын төрийн өмч бөгөөд радио давтамж, давтамжийн зурвас хуваарилах эрх дан ганц Засгийн газарт байна”, мөн 5.2 зүйлд “ХХЗХ нь Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллага мөн” гэж заасан нь хараат бус байгууллага биш гэдгийг илтгэнэ.

Энэ нөхцөл байдал нь радио долгионы давтамжийн хуваарилалт, зохицуулалт хараат бус явагдах боломжийг хааж байна.

Интернэт

Монгол Улсад хэрэглэгчид дотоод, гадаадын аль ч сайтад нэвтэрч, нийгмийн сүлжээнд нэгдэж, харилцахыг төрөөс хязгаарласан зохицуулалт байхгүй.

“Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-д “контент” гэдгийг “харилцаа, холбооны сүлжээгээр дамжиж байгаа тэмдэгт, дохио, текст, зураг, дуу, авиа, дүрс, бичлэг болон бүх төрлийн мэдээ мэдээллийг тоон хэлбэрт хувиргасан бүтээгдэхүүнийг хэлнэ” гэж тодорхойлжээ. Харин цахим шуудан, балк болон спам захидал, хувь хүмүүсийн хоорондын харилцаа (телефон яриа, факс, айпи телефон яриа гэх мэт) контентэд хамаарахгүй. Монгол Улсын Засгийн газрын баталсан “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай 2013 оны 01 тоот тогтоолоор мэдээллийн сайтуудад тавигдах шаардлага, домэйн хаяг олгох ажлыг зохицуулах журам гаргахыг ХХЗХ-д үүрэг болгов. Үндэсний Дата төвөөс сэтгэгдлийн нэгдсэн системийн техникийн ажиллагааг хангаж, Улсын бүртгэлийн ерөнхий газар сайтууд дээр сэтгэгдэл бичиж буй хэрэглэгчдийн тухай мэдээллийг бүртгэж байх үүрэг хүлээсэн. Тэд хэрэглэгчдийн тухай мэдээлэл бүрдүүлэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сан болон үүрэн телефон хэрэглэгчдийн мэдээллийг ашиглахаар зохицуулсан. Цахим орчинд нэрээ нууцлах эрхийг хязгаарласан энэхүү тогтоол хүчин төгөлдөр үйлчилсээр байна.

НҮБ-ын Үзэл бодлын эрх чөлөөний Тусгай илтгэгч, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-ын Хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгч болон Америкийн муж улсуудын байгууллага (OAS)-ын Үзэл бодлын эрх чөлөөний Тусгай илтгэгч нарын 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталсан Хамтарсан Тунхаглалд “Интернэтийн үйлчилгээ, цахим хуудас, блог эрхлэх, онлайнар мэдээлэл түгээх, интернэтийн өргөн нэвтрүүлэг дамжуулахад төрийн аливаа байгууллагад бүртгүүлэх, тэднээс зөвшөөрөл авахыг хэнээс ч шаардах ёсгүй. Энэ нь цэвэр техникийн зориулалттай домэйн нэр эзэмшлийн бүртгэл, мөн арилжааны үйл ажиллагааны бүхий л төрөлд ялгаварлалгүйгээр хэрэглэгдэх хэрэглээний ерөнхий журамд хамаарахгүй” хэмээн заасан байдаг.

Гэвч ХХЗХ нь хязгаарлалтыг дүрэм журмаар тогтоосоор байна. “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын 3.4 дэх хэсэгт зааснаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй мэдээ мэдээллийн вэбсайтын үйлчилгээ эрхлэгч нь Зохицуулах хороонд бүртгүүлэх үүрэг хүлээж байна.

Энэ журмаар вэбсайтын үйлчилгээ эрхлэгчид нь хэрэглэгч контент үүсгэх боломжтой, хэрэглэгчийн сэтгэгдэл үлдээх хэсэгтэй бол дараах зохицуулалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно. Үүнд:

- Зохицуулах хорооноос ажиллуулж байгаа үгийн шүүлтүүр программыг заавал ашиглах;
- Хэрэглэгчийн интернэт хаягийг (IP address) бүтнээр нь хэрэглэгчийн үүсгэсэн контентын дээр нийтэд харагдахуйц байрлуулах;

- Хэрэглэгч дурын нэр (username), имэйл хаягаар логин хийх сэтгэгдэл үлдээх боломжийг бүрдүүлэх
- Тухайн сэтгэгдэлтэй холбоотой үүсэх логийг багадаа 6 сар хадгална.

Энэ ерөнхий нөхцөл шаардлагыг биелүүлээгүй вэбсайтын үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлана.

Зохицуулах хороо нь холбогдох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хууль, тогтоомж зөрчсөн тухай албан ёсны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн вэб сайтын үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэнэ. Мэдэгдсэнээс хойш 24 хүртэлх цагийн дотор, шаардлагатай гэж үзвэл нэн даруй уг зөрчлийг арилгах арга хэмжээ авч хариуг мэдэгдэнэ /9.2.1/. Эрх бүхий байгууллагаас Монгол Улсад хандах хандалтыг хязгаарлах тухай ирүүлсэн албан ёсны мэдэгдэл, албан бичигт үндэслэн тухайн вэбсайтын үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэл хүргүүлэхгүйгээр вэбсайтын хандалтыг нэн даруй хязгаарлаж болно.

Зохицуулах хороо зөрчлөөс хамааруулан тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан эдийн засгийн хариуцлага хүлээлгэх эсвэл хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх; захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх; тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах; хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах эрхтэй байхаар журамласан байна.

Өөрийн зохицуулалт

Урт хугацааны яриа хэлэлцүүлгийн үр дүнд анхны өөрийн зохицуулалтын байгууллага болох Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл 2015 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр албан ёсоор байгуулагдсан. Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах зөвлөл удирдах бөгөөд телевиз, радиогийн ёс зүйн хороо (15 хүн), сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хороо (15 хүн), ажлын алба, гүйцэтгэх захиралтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Сэтгүүл зүйн бүтээл дээрх ёс зүйн алдаа гаргасан эсэх асуудлаар 2015-2017 оны хооронд хэвлэл мэдээллийн байгууллагад холбогдох нийт 118гомдлыг хянан шийдвэрлэсэн бол 2017 онд 16 иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 49 хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох гомдлыг хэлэлцжээ.

Сэтгүүлчийн нууц эх сурвалж

Монгол Улсад сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах хууль одоо болтол байхгүй байна. Зөвхөн Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан.

“Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын 8 дахь “Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална” гэсэн заалтаар сэтгүүлчдэд нууц эх сурвалжаа хамгаалах ёс зүйн үүргийг хүлээлгэдэг.

Эдгээрээс гадна нэг олзуурхууштай зүйл нь 2016 онд батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тоот тогтоолоор баталсан явдал юм. Учир нь тус хөтөлбөрийн 4.1.8 дахь хэсэгт хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус байдал, сэтгүүлч аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлууд хийхээр тусгаад байна. Тухайлбал:

- хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээлэл олж авах, түгээх эрхийг баталгаажуулах /4.1.8.1./;
- эрэн сурвалжлах замаар авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлчийг аливаа дарамт, шахалтаас хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагааных нь улмаас эрүүгийн хариуцлагад татах явдлыг өөрчилж, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бий болгох /4.1.8.2./;
- хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан, хараат бус байдал, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх /4.1.8.3./; гэж тус тус заасан.

Эдгээрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө батлагдсантай холбоотойгоор сэтгүүлчийн нууц эх сурвалж, шүгэлдэгчийг хамгаалсан эрх зүйн орчин бүрдэнэ гэсэн хүлээлт өндөр байгаа юм.

Олон улсын зөвлөмж

НҮБ-ын Хүний эрхийн хороо 2017 оны 7-р сарын 6-7-ний өдрүүдэд Монголын Засгийн газрын Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын хэрэгжилтийн тухай 6 дахь удаагийн ээлжит тайланг хэлэлцэж, мөн сарын 24-ний өдрийн уулзалтаараа Монгол Улсад өгөх Дүгнэлт зөвлөмжийг баталсан билээ. Үүнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой дараах дүгнэлт зөвлөмжийг ирүүлсэн юм.

37. Эрх мэдэлтнүүдийн зүгээс хэвлэл мэдээлэл, тэр дундаа интернэтэд суурилсан хэвлэл мэдээлэлд хуулиар өргөн хүрээнд хязгаарлалт тавьж буй, мөн нууцлалтай холбоотой зүйл заалтыг хэт өргөн хүрээнд тайлбарлаж байгаагаас мэдээлэл авах эрх хязгаарлагдаж байгаад Хороо санаа зовниж байна. Хороо, Эрүүгийн хуулиас гүтгэлэг доромжлолтой холбоотой ерөнхий зүйл заалтыг халсныг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ, уг хуулийн гүтгэлэг доромжлолтой холбоотой бусад зүйл заалт хэвээр үлдсэн төдийгүй үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэт хязгаарлах сөрөг үр дагавар бүхий Иргэний хуулийн нэр төр гутаахтай

холбоотой зүйл заалтыг ашиглах явдал нэмэгдэж буйд санаа зовниж байна. Мөн Хорооны зүгээс сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг сүрдүүлсэн, тэдэнд халдсан явдлуудад эмзэглэж байна. (Зүйл 19, 21, 22, 26).

38. Оролцогч улс нь үзэл бодолтой байх эрх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөний талаарх Хүний эрхийн хорооноос 2011 онд гаргасан 34 дүгээр ерөнхий тайлбарыг анхааралдаа авч, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг аливаа байдлаар хязгаарлахдаа Пактын 19 дүгээр зүйлийн 3 дугаар заалтыг чанд мөрдөх ёстойг анхаарвал зохино. Нэр хүнд гутаан доромжлох нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах шалтгаан болохгүй бөгөөд Иргэний болон Эрүүгийн хуулийн нэр төрд халдах, гүтгэлэг доромжлолтой холбоотой зүйл заалтууд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг боомилох ёсгүй. Оролцогч улс Эрүүгийн хуулиас гүтгэлэг доромжлолтой холбоотой зүйл заалтыг бүрэн халж, гүтгэлэг доромжлолтой холбоотой хэрэг нь эрх чөлөөг хасах үндэс болох ёсгүй, мөн гүтгэлэг доромжлолтой холбоотой эрүүгийн, иргэний хууль нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг боомилохгүй байхад анхаарвал зохино. Үүнээс гадна сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг аливаа сүрдүүлэг заналхийлэл, халдлагаас хамгаалах, эдгээр төрлийн халдлагыг нэн даруй мөрдөн шалгаж, буруутай этгээдүүдэд зохих шийтгэл ногдуулж байх нь зүйтэй.